



СЭЛЭНГЭ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/70.

Цагаантолгой

Хөдөө аж ахуйн ээлжит тооллого  
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.1, 59.1.23, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Засгийн газрын 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн “Хөдөө аж ахуйн тооллоно явуулах тухай” 74 дүгээр тогтоол, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн А/210 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө аж ахуйн тооллогыг сумын хэмжээнд 2022 оны 06 дугаар сарын 06-наас 6 дугаар сарын 17-ны өдрийн хооронд багтаан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч	Б.Мөнх-Эрдэнэ-(Сумын Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга	Х.Хатанчимэг-(Төрийн сангийн мэргэжилтэн)
Гишүүд	З.Цолмон-(Хөдөө аж ахуйн тасгийн дарга)
	Л.Сэлэнгэсайхан-(Ивэн багийн Засаг дарга)
	Б.Золбаяр-(Хушаат багийн Засаг дарга)
	Ц.Батсайхан-(Газрын даамал)
	Ч.Төгсбаатар-(Хушаат багийн байгаль хамгаалагч)

2.Хөдөө аж ахуйн ээлжит тооллогын бэлтгэл ажлыг бүрэн хангаж, батлагдсан төлөвлөгөөний дагуу чанартай зохион байгуулж, заасан хугацаанд дүнг Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтэст мэдээлж ажиллахыг төрийн сангийн мэргэжилтэн (Х.Хатанчимэг), захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, сумын Засаг даргын орлогч (Б.Мөнх-Эрдэнэ) нарт даалгасугай.

С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: *Н. Хатаншиг*  
Хянасан: *С. Шимсүрэн*  
Хувь: *2*